

Б. Наранчимэг, эдийн засагч-хүн ам зүйч.  
МУИС, ХАССТ-ийн Эрдэм шинжилгээний ажилтан

### **Бүрэн дундаас дээш боловсролтой залуучуудын жендерийн байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ**

*Манай улсад боловсрол олох үйл явцад хүйсээр ялгаварлан гадуурхдаггүй ч, сүүлийн жилүүдэд боловсролын салбарт, ялангуяа, гурав дахь түвшний сургалт буюу их дээд сургууль, коллежид суралцаж буй залуучуудын дунд хүйсийн харьцаа ихээхэн алдагдаж, эмэгтэйчүүд давамгайлах байдал ажиглагдах болжээ. Уг хүйсийн харьцааны тэнцвэрт бус байдлын олон талын сөрөг нөлөөг судлаач энэ ажлаараа гарган, асуудал дэвшүүлсэн бөгөөд Монгол улсын бүрэн дундаас дээш боловсролтой залуучуудын хүйсийн тэнцвэргүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, тэдгээр хүчин зүйлүүдийн хамаарлыг судлахыг зорьсон байна.*

*Судлаач ажилдаа 1999 онд ЭМНХЯ-ны захиалгаар МУИС-ийн ХАЗССТ-өөс явуулсан “Монголын залуучуудын жендерийн байдал” түүвэр судалгааны мэдээллийг ашиглан статистик шинжилгээ хийж, асуудалтай холбоотой өөрийн санал, зөвлөмжийг гаргажээ.*

### **Асуудлын эргэн тойронд**


Аливаа улс орны нийгмийн хөгжлийн гол тулгуур багана нь эдийн засгийн хөгжил, улс төрийн хөгжил болдог ба эдгээр нь хүний хөгжил дээр суурилдаг (Нийгмийн Хөгжлийн Төв Зөвлөх Нэгж, 1997). Хүний хөгжлийн асуудлын салшгүй нэг хэсэг нь жендерийн асуудал билээ (А.Батжаргал, 2001). Манай улс нь бүх иргэдээ тэгш эрх, боломж нөхцлөөр хангах талаар түүхэн уламжлалтай орон бөгөөд эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдийн нэгэн адил иргэний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлдэг (Монгол Улсын Их Хурал, 1992). Тийм ч учраас өнөөдөр манай улсын эмэгтэйчүүдийн байдал олон талаараа хөгжингүй орны эмэгтэйчүүдийн байдалтай адил төстэй, харин хөгжиж буй орнуудын эмэгтэйчүүдийн байдлаас хавьгүй дээр байгаа юм (МУ-ын Засгийн Газар, НҮБХХөтөлбөр, 1997). Хөгжиж буй улс орнуудтай харьцуулахад ялангуяа боловсролын асуудал дээр манай улс шиг эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхтэй ойролцоо түвшинд байдаг улс орон цөөхөн. Манай улс боловсролын талаар ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх тухай НҮБ-ын конвенцэд 1964 онд, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүхий л хэлбэрийг устгах тухай конвенцэд 1981 онд нэгдэн орсон байна (ХАЗССТ, 1999).

Монгол улсын хүн амын 1989 оны тооллогоор бичиг үсгийн мэдлэгийн түвшин нийт хүн амын хувьд 96.5%, эмэгтэйчүүдийн хувьд 94.9%, эрэгтэйчүүдийн хувьд 98.2% байв. Харин 2000 оны тооллогоор эмэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин 97.5% болтлоо өсөж эрэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшинд бараг хүрч очсон байхад эрэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт 98% болж буурчээ. Энэ нь шилжилтийн үед бий болсон сургууль завсардалттай нягт холбоотой гэж үзэж байна.(НҮБ-ын ЭХС, 2000). Тухайлбал, статистик мэдээгээр 1989-1996 онуудад нийт 166000 хүүхэд сургууль завсардсан байв. Эдгээр хүүхдийн

гуравны хоёр нь 1-4 дүгээр ангиас сургуулиас завсардсан ба тэдний 70% нь эрэгтэй хүүхдүүд байсан байна (БСШУЯ, 1996).

Хүн амын боловсролын түвшнийг авч үзэхэд 1989 онд 10, түүнээс дээш насны хүн амд дээд боловсролтой хүмүүсийн эзлэх хувь 7 байснаа 2000 онд 7.6% болон өсч, харин боловсролгүй хүмүүсийн эзлэх хувь 11.8 %-аас 11.6% хүртэл, бага боловсролтой хүмүүсийн эзлэх хувь 30.5%-аас 23.5% хүртэл буурсан байна. Хүйсийн хувьд авч үзвэл, 1989 онд боловсролгүй эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс илүү байсан бол 1989-2000 оны хооронд боловсролгүй эмэгтэйчүүдийн эзлэх хувь буурч, харин ийм эрэгтэйчүүдийн эзлэх хувь өссөнөөр 2000 он гэхэд бараг ижил түвшинд хүрчээ. 2000 оны байдлаар бага, дунд, техникийн болон мэргэжлийн боловсрол эзэмшсэн эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс ялимгүй илүү байна. Харин боловсролын өндөр түвшинд, тухайлбал тусгай мэргэжлийн дунд, бүрэн бус дээд, дээд боловсролын түвшинд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү байна(ҮСГ, 2001).

Нийт хүн амын сургуульд хамрагдалтын түвшинг авч үзэхэд шилжилтээс өмнөх үед буюу 1991 оныг хүртэлх хугацаанд бүх шатны сургуулийн хамран сургалтын хувь хэмжээ тасралтгүй өсч ирсэн бол 1991-1993 онуудад ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн анхан дунд шатны сургуульд суралцагсдын тоо эрс буурч, сургууль завсардалт нэмэгдсэнээр сургуульд хамрагдалтын нэгдсэн индекс хүрсэн түвшингээсээ ихээхэн доошлоход хүрчээ (Зураг 1).



Мэдээллийн эх үүсвэр: А.Батжаргал, 2000

Сургуульд хамрагдалтын индексийн өсөлт, бууралт нь суурь боловсрол олгох насны сургуульд хамрагдалтаас голлон шалтгаалдаг бөгөөд 1990 оны эцсийн байдлаар суурь боловсрол олгох насны хамран сургалт эрэгтэйчүүдийн хувьд 89.6%, эмэгтэйчүүдийн хувьд 97.4% байсан бол 1993 оны эцэст харгалзан 17.2 болон 13.6 хувиар буурч эрэгтэйчүүдийн хувьд 72.4%, эмэгтэйчүүдийн хувьд 83.8% болсон байна. 1993 оноос хойш сургуульд хамрагдалтын индекс бага зэрэг өсөх хандлагатай байгаа боловч хүйсийн тэнцвэрт байдал алдагдсан хэвээр байна(А.Батжаргал, 2001). 2000 оны тооллогын мэдээгээр суурь боловсрол олгох насны хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын индекс эмэгтэйчүүдийн хувьд 89.6%,

эрэгтэйчүүдийн хувьд 83.4% болсон байна. Эндээс 1990-1999 онуудад 8-15 насны хүн амын тоог гаргахдаа тухайн насны хүн амыг 100% хамруулж чаддаггүй байсан ба 2000 оны тооллогоор энэ насны хүн амыг бүрэн хамруулснаар хамран сургалтын индекс 1999 оны түвшнээс буурч гарсан байж болох юм.

Манай улс гурав дахь шатны боловсрол эзэмшүүлэх сургалт буюу мэргэжлийн сургууль болон коллеж, их, дээд сургуулиудад суралцаж байгаа эрэгтэй, эмэгтэй оюутны тооны харьцаа 1:2 болсон дэлхий дээрх цөөхөн орны нэг болоод байна (МУ-ын ЗГ, ГЯ, 2000).

## **Үндэслэл**

Монгол улс бол залуучуудын орон: нийт хүн амын 68.1 гаруй хувь нь 30 хүртэлх насны залуус (ҮСГ, 2001) бөгөөд улс орны өнөөгийн дүр төрхийг тодорхойлогч нь залуучууд юм. Гэтэл өнөөдрийн байдлаар залуучуудын боловсролын түвшин дэх хүйсийн тэнцвэргүй байдал нэлээд хурцадсан асуудал болоод байна (МУ-ын ЗГ, ГЯ, 2000).

Олон улсын хэмжээнд хийж буй дүгнэлтүүдэд, харьцуулж буй 2 зүйлийн хоорондох ялгаа 10 пунктээс дээш зөрүүтэй бол тэнцвэрт байдал алдагдсан байна гэж үздэг (А.Батжаргал, 2001). Манай улсад боловсрол олох үйл явцад хүйсээр ялгаварлан гадуурхдаггүй ч боловсролын салбарт хүйсийн харьцаа их алдагдаж, эмэгтэйчүүд давамгайлах байдал ажиглагдаж байна (ЭМСТ, 1997). Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын үр дүн ч үүнийг мөн нотлон харууллаа (ҮСГ, 2001).

Дээд боловсролтой эмэгтэйчүүдэд өөрөөсөө дээгүүр юмуу ойролцоо боловсролтой эрэгтэйг сонгох боломж хязгаарлагдмал болж байгаагийн зэрэгцээ манай улс эртнээс уламжилж ирсэн ёс заншлаар эрэгтэй хүн өрхийн тэргүүн байдаг боловч боловсрол нимгэн залуучууд маань өрх гэрээ аваад явах чадваргүй болоод байгаа юм. Энэ эргээд нийгэм, эдийн засаг, хүн амын амьжиргаанд нөлөөлөх учир залуучуудын асуудлыг, ялангуяа дээд боловсролын түвшин дэх залуучуудын хүйсийн асуудлыг чухлаар авч үзэх шаардлага тулгараад байгаа билээ. Энэ хүйсийн зөрүүтэй байдал нь магадгүй ахлах ангид ороход босго тавьж байгаа явдалтай ч нэг талаараа холбоотой байж болох талтай (А.Батжаргал, 2001). Тиймд боловсролын аль ч түвшинд залуучуудын хүйсийн зөрүүтэй байдал, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлийг судалсаны үндсэн дээр ирээдүйд залуучуудын боловсролын асуудал дээр төр засгаас ямар бодлого баримтлах хэрэгтэй вэ гэдгийг тодорхойлох шаардлагатай бөгөөд статистик шинжилгээний үндсэн дээр “Залуучуудын боловсрол дахь жендерийн байдалд нөлөөлөх хүчин зүйл”-ийг тодорхойлох нь чухал юм.

## **Судалгааны зорилго**

Судалгааны үндсэн зорилго нь Монгол улсын бүрэн дундаас дээш боловсролтой, 17-35 насны залуучуудын хүйсийн тэнцвэргүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох, тэдгээр хүчин зүйлүүдийн хамаарлыг судлах явдал болно. Энэхүү зорилгод хүрэхийн тулд дараах


зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд: Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн бүрэн дундаас дээш боловсролын түвшинд нөлөөлөх:

- ◆ Хүн ам зүйн хүчин зүйлсийг тодорхойлох;
- ◆ Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг тодорхойлох;
- ◆ Жендерийн талаарх мэдлэг, хандлага хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох зэрэг болно.

### Судалгааны логик хүрээ

Судалгааны логик хүрээ нь энэ сэдэвтэй холбоотой ном, эрдэм шинжилгээний бусад ажлууд дээр үндэслэн боловсруулагдсан бөгөөд шалтгааны загвараар шинжилгээг хийлээ. Шинжилгээний хүрээнд бүрэн дундаас дээш боловсролтой залуучууд гэсэн хамаарах хувьсагч, хүн ам зүйн хүчин зүйл, нийгэм, эдийн засгийн хүчин зүйл, жендерийн талаархи мэдлэг, хандлага гэсэн гурван бүлэгт ангилагдсан үл хамаарах хувьсагчдыг сонгон авч үзсэн. Судалгаанд хамрагдсан залуучуудын боловсролын түвшний шалтгааны загварыг “Загвар 1”-д харуулав.

### Загвар 1. Монгол улсын 17-35 насны залуучуудын боловсролын түвшний шалтгааны загвар



### Шинжилгээний таамаглал :

Энэхүү шинжилгээг хийхээс өмнө дараахь таамаглалыг дэвшүүлж байна:

- ◆ Залуучуудын амьдралд хамгийн чухал зүйл (мэдлэг, бусад зүйлс)-ийг илэрхийлсэн хувьсагч нь хамаарах хувьсагч болох бүрэн дундаас дээш боловсролтой залуучуудын боловсролын түвшин дэх хүйсийн ялгаатай байдалд шууд нөлөөлнө.
- ◆ Залуучуудын жендерийн талаархи мэдлэг хандлага нь хамаарах хувьсагчид нөлөөлөхгүй.

### Мэдээллийн эх үүсвэр, арга зүй

Энэ судалгаанд 1999 онд Эрүүл Мэнд Нийгмийн Хамгааллын Яамны захиалгаар Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төвөөс явуулсан “Монголын залуучуудын гендерийн байдал” судалгаагаар цуглуулагдсан тоо мэдээллийг ашигласан. Судалгааны түүвэрлэлтэнд Булган, Өмнөговь, Ховд, Хэнтий гэсэн 4 аймаг, Улаанбаатар хотын 17-35 насны нийт 1386 хүн хамрагдсаны 49.9% нь эрэгтэйчүүд, 50.1% нь эмэгтэйчүүд байлаа.

Залуучуудын боловсролд нөлөөлж болох зарим нэг хүчин зүйлүүдийг сонгож авахдаа хэд хэдэн үзүүлэлтүүдийг нэгтгэж нэгдсэн индекс зохиосон. Тухайлбал, Залуучуудын гендерийн талаархи мэдлэг, хандлага нь боловсролын түвшинд хэрхэн нөлөөлөхийг тодорхойлохын тулд гендерийн талаархи мэдлэг болон гендерийн хандлага гэсэн индексүүдийг зохиосон. Гендерийн талаархи мэдлэг гэсэн хувьсагч нь 4 багцүзүүлэлтээс зохиосон нэгдсэн индекс, харин гендерийн хандлага гэсэн үзүүлэлт нь 15 багц үзүүлэлтээс зохиосон нэгдсэн индекс болно.

$\chi^2$  - ийг хамаарах болон үл хамаарах хувьсагчдын хоёр хүчин зүйлийн хамаарлыг судлахад, харин *олон хүчин зүйлийн ложистик регрессийн загваруудыг* хүн ам зүйн хүчин зүйлс болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлс, гендерийн талаархи мэдлэг, хандлага гэсэн гурван бүлэг хүчин зүйлсийн бүрэн дундаас дээш боловсролтой залуучуудын боловсрол дахь хүйсийн ялгаатай байдалд нөлөөлж буй хавсарсан нөлөөллийг судлахад ашигласан. Шинжилгээг нийгмийн судалгааны статистик шинжилгээний багц программ SPSS дээр хийв.

Залуучуудын боловсролын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлс нь эрэгтэй, эмэгтэй хоёр хүйст ялгаатай байна гэж таамаглаад хүйс тус бүрд шинжилгээг хийж үр дүнг зэрэгцүүлж үзсэн.

### **Мэдээллийн хязгаарлагдмал байдал**

Шинжилгээнд мэдээллийн хоёрдогч эх үүсвэрийг ашигласан учраас тодорхой асуултуудын хүрээнд үл хамаарах хувьсагчид хязгаарлагдмал байдлаар сонгогдсон. Тухайлбал, нийгэм эдийн засгийн статусыг тодорхойлж болохуйц өрхийн орлого, амьжиргааны түвшин гэх мэт үзүүлэлтүүдийн талаар нэгдсэн мэдээлэл байгаагүй учраас үүнийг төлөөлүүлэх байдлаар дараахь хувьсагчуудыг сонгосон болно. Үүнд:

- ◆ Орлогын хараат байдал (Хараат, хараат бус) гэсэн хувьсагчийг шинээр үүсгэн сонгон авсан.
- ◆ Мөн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан цаашид мэргэжил боловсролоо дээшлүүлэх боломж нь боловсролын түвшинд хэрхэн нөлөөлөхийг тодорхойлохын тулд 3 багц үзүүлэлтийг нэгтгэсэн.

### **Судалгаанд хамрагдагсдын шинж байдал**

Судалгаанд 17-35 насны 1386 залуучууд хамрагдсаны 695 нь эрэгтэй, 691 нь эмэгтэй байв. Харин насны бүлгээр авч үзэхэд ерөнхийдөө жигд тархацтай байна. Нийт судалгаанд хамрагдагсдын 50.1% нь эрэгтэй, 49.9% нь эмэгтэй, 31.1% нь 17-21 насны, 24.3% нь 22-25 насны, 44.6% нь 26 ба

түүнээс дээш насны залуучууд байна. Судалгаанд хамрагдсан залуучуудын 34.1% нь бүрэн дундаас дээш боловсрол эзэмшсэн байв. Залуучуудын боловсролын түвшин ба хүйс нь хоорондоо маш хүчтэй хамааралтай байлаа.

Залуучуудын 41.8% нь огт гэрлээгүй, 48% нь гэрлэж байсан, үлдсэн хувь хамт амьдардаг бөгөөд тэдний орлогын хараат байдлыг нь авч үзвэл 47.1% нь хараат, 52.9% нь хараат бус гэж хариулжээ. Эдгээр залуучуудын 45.5% нь ямар нэгэн мэргэжил эзэмшсэн байв.

Судалгаанд хамрагдагсдын 66.3% нь хөдөө, 33.7% нь хотод амьдардаг залуучууд байлаа.

Эдгээр залуусын жендерийн талаархи мэдлэг, түүнд хандах хандлага ямар байгааг авч үзэхийн тулд хэд хэдэн багц асуултаас индекс зохиож хариултыг шалгаж үзсэн болно. Судалгаанд хамрагдагсдын жендерийн талаархи мэдлэг 5.7% нь муу, 90.3% нь дунд, 4% нь сайн гэсэн үнэлгээ авав. Харин жендерийн байдалд хандах хандлагын хувьд нэлээд сонирхолтой үр дүн гарсан байна. Залуучуудын 98.3% нь жендерийн асуудлыг зөвшөөрдөггүй, дөнгөж 1.7% нь зөвшөөрдөг гэсэн үнэлгээ авсан байна. Энэ нь магадгүй өвөг дээдсээс уламжилж ирсэн ёс заншил, эрэгтэй хүнийг өрхийн тэргүүн хэмээн хүндлэх явдал болон нийгмийн сэтгэл зүйд тогтсон эмэгтэй хүн гэрийн ажил хийж, хүүхдээ асардаг гэх мэт ойлголтуудаас шалтгаалсан байж болох юм.

Судалгаанд хамрагдагсдын 30% нь амьдралд мэдлэг, боловсролыг хамгаас чухалчилж үздэг бол 70% нь өөр бусад зүйлсийг (ажил, мөнгө, гэр бүл, итгэл, эрх чөлөө, эрүүл мэнд г.м) чухал хэмээн үзжээ. Залуучуудын цаашдаа мэдлэг, боловсролоо дээшлүүлэх боломжтой эсэхийг асууж судлахад 67.9% нь боломжтой, 32.1% нь боломжгүй гэжээ.

### Хоёр хүчин зүйлийн шинжилгээ

Сонгож авсан үл хамаарах хувьсагчдыг залуучуудын боловсролын түвшинтэй ямар хамааралтай байгааг хоёр хүчин зүйлийн шинжилгээгээр судалж үзье.

Хүснэгт 1. Хүн ам зүйн хүчин зүйлс ба боловсролын түвшний хоорондох хамаарал, хүйсээр.

ХҮН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛС:	Бүрэн дундаас дээш боловсролтой залуучууд			
	Эрэгтэй		Эмэгтэй	
	Бүгдэд эзлэх хувь, %	Бүгд	Бүгдэд эзлэх хувь, %	Бүгд
<b>Нас</b>				
17-21	6.3	222	9.6	209
22-25	24.2	165	43.0	172
26 ба түүнээс дээш	47.1	308	57.7	310
	$\chi^2 =$	106.990	$\chi^2 =$	122.399
	df =	2	df =	2
	P =	0.000	P =	0.000
<b>Сууршил</b>				
Хөдөө	21.6	459	33.7	460

Хот	42.4	236	51.1	231
	$\chi^2 =$	33.013	$\chi^2 =$	19.451
	df =	1	df =	1
	P =	0.000	P =	0.000
<b>Гэрлэлтийн байдал</b>				
Огт гэрлээгүй	14.2	331	21.8	248
Гэрлэж байсан	42.0	305	50.8	360
Хамт амьдардаг	40.7	59	43.4	83
	$\chi^2 =$	64.472	$\chi^2 =$	52.474
	df =	2	df =	2
	P =	0.000	P =	0.000
<b>Мэргэжилтэй эсэх</b>				
Мэргэжилтэй	65.8	301	82.1	329
Мэргэжилгүй	0.3	394	0.8	362
	$\chi^2 =$	358.552	$\chi^2 =$	475.952
	df =	1	df =	1
	P =	0.000	P =	0.000
<b>Бүгд</b>	<b>28.6</b>	<b>695</b>	<b>39.5</b>	<b>691</b>

Тэмдэглэгээ:  $\chi^2$  — ач холбогдлын түвшин: итгэмжлэх түвшин нь  $\alpha=95\%$   
 $P<0.0001$  бол хоёр хувьсагч хоорондоо маш хүчтэй хамааралтай.  
 $P<0.01$  бол дунд зэрэг хамааралтай .  
 $P<0.05$  бол сул хамааралтай.

Шинжилгээнээс, хүн ам зүйн хүчин зүйлс ба боловсролын түвшин хоорондын хамаарал хоёр хүйст хоёуланд нь хоорондоо маш хүчтэй хамааралтай гэсэн үр дүн гарчээ. 17-21 насны эрэгтэйчүүдийн 6.3%, 22-25 насны эрэгтэйчүүдийн 24.2%, 26 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүдийн 47.1% нь бүрэн дундаас дээш боловсрол эзэмшсэн байв ( $p<0.000$ ). Харин эмэгтэйчүүдийн хувьд энэ үзүүлэлт нь харгалзан 9.6%, 43%, 57.7% байлаа ( $p<0.000$ ). Эндээс харахад залуу эмэгтэйчүүдийн боловсролын түвшин эрэгтэйчүүдийнхээс өндөр байгаа юм.

Хөдөө амьдардаг эрэгтэйчүүдийн 21.6%, эмэгтэйчүүдийн 33.7%, хотод амьдардаг эрэгтэйчүүдийн 42.4%, эмэгтэйчүүдийн 51.1% нь бүрэн дундаас дээш боловсролтой ( $p<0.000$ ) байгаагаас оршин суугаа газрын байршлаас хамаараад залуучуудын боловсролын түвшин 2 хүйст ялгаатай нь харагдаж байна.

Дээрхи хүснэгтээс харахад огт гэр бүл болоогүй эрэгтэйчүүдийн 14.2%, гэрлэж байсан эрэгтэйчүүдийн 42% нь бүрэн дундаас дээш боловсрол эзэмшсэн нь ийм эмэгтэйчүүдийнхээс 7-9 пунктээр бага байна. Харин хамт амьдардаг эрэгтэйчүүдийн 40.7% бүрэн дундаас дээш боловсролтой байгаа нь ийм эмэгтэйчүүдийнхээс 3 орчим пунктээр бага байв. Энэ нь гэрлэлтийн статус залуучуудын боловсролын түвшинтэй хүчтэй хамааралтай байгааг илэрхийлж байна ( $p<0.000$ ).

Судалгаанд хамрагдсан мэргэжилтэй эмэгтэйчүүдийн 82.1%, эрэгтэйчүүдийн 65.8% ( $p<0.000$ ) нь бүрэн дундаас дээш боловсролтой байгаагаас эмэгтэйчүүдийн ихэнхи нь мэргэжлийн сургууль, коллеж, их дээд сургууль гэх мэт урт хугацааны сургалтын үр дүнд мэргэжил эзэмшдэг, харин эрэгтэйчүүдийн хувьд курс, дамжаа, богино хугацааны сургалтаар

дамжуулан мэргэжил эзэмших нь эмэгтэйчүүдийг бодвол илүү байдаг гэсэн дүгнэлт гарч байна.

Судалгаанд хамрагдагсдын нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс ба боловсролын түвшний хоорондох хамаарлыг авч үзлээ (Хүснэгт 2).

Хүснэгт 2. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлс ба боловсролын түвшний хоорондох хамаарал, хүйсээр.

НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС:	Бүрэн дундаас дээш боловсролтой залуучууд			
	Эрэгтэй		Эмэгтэй	
	Бүгдэд эзлэх хувь, %	Бүгд	Бүгдэд эзлэх хувь, %	Бүгд
<b>Орлогын хараат байдал</b>				
Хараат	20.3	325	29.0	328
Хараат бус	35.9	370	49.0	363
	$\chi^2 =$	20.707	$\chi^2 =$	29.048
	df =	1	df =	1
	P =	0.000	P =	0.000
<b>Цаашид мэргэжил, боловсролоо дээшлүүлэх боломж<sup>A</sup></b>				
Боломжгүй	40.6	155	50.9	173
Боломжтой	34.4	340	43.9	353
	$\chi^2 =$	1.788	$\chi^2 =$	2.261
	df =	1	df =	1
	P =	0.181	P =	0.133
<b>Амьдралд хамгийн чухал зүйл</b>				
Боловсролоос бусад зүйл	32.1	511	40.7	459
Боловсрол	19.0	184	37.1	232
	$\chi^2 =$	11.313	$\chi^2 =$	0.869
	df =	1	df =	1
	P =	0.001	P =	0.351
<b>Бүгд</b>	<b>28.6</b>	<b>695</b>	<b>39.5</b>	<b>691</b>

Тэмдэглэгээ:  $\chi^2$  – ач холбогдлын түвшин: итгэмжлэх түвшин нь  $\alpha=95\%$   
 $P < 0.0001$  бол хоёр хувьсагч хоорондоо маш хүчтэй хамааралтай.  
 $P < 0.01$  бол дунд зэрэг хамааралтай.  
 $P < 0.05$  бол сул хамааралтай.

<sup>A</sup> – Энэ асуултанд 495 эрэгтэй, 526 эмэгтэй хариулсан

Орлогын хувьд бусдаас хараат байдаг эмэгтэйчүүдийн хувь (29) эрэгтэйчүүдийнхээс 9 пунктээр өндөр байгаагаас харвал, эцэг, эхчүүд охидууддаа хөвгүүдээс арай илүү хөрөнгө оруулалт хийдэг гэж дүгнэж болох юм ( $p < 0.000$ ). Залуучуудын орлогын хараат байдал ба боловсролын түвшин нь хоорондоо маш хүчтэй хамааралтай гэсэн үр дүн гарчээ.

Хоёр хүчин зүйлийн шинжилгээгээр залуучуудын цаашид мэргэжил, боловсролоо дээшлүүлэх боломж нь боловсролын түвшинтэй ямар ч хамааралгүй гэсэн үр дүн гарчээ. Гэхдээ цаашид мэргэжил, боловсролоо дээшлүүлэх боломжтой бүрэн дундаас дээш боловсролтой залуучуудын хувийн жин 34-44 байгаа нь маш сайн үзүүлэлт юм. Учир нь одоогийн байдлаар бүрэн дундаас дээш боловсролтой байгаа залуучууд ирээдүйд түүнээс ч илүү өндөр түвшний боловсрол эзэмших боломж нь харьцангуй өндөр байна.



Боловсролыг амьдралдаа хамгаас чухал гэж үзсэн эрэгтэйчүүдэд бүрэн дундаас дээш боловсролтой эрэгтэйчүүдийн эзлэх хувь (19,  $p=0.001$ ) эмэгтэйчүүдийнхээс бараг 2 дахин бага байгаа нь бүрэн дундаас дээш түвшний боловсрол эзэмшүүлэх сургуулиудад суралцаж буй эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн харьцааг 2:1 байхад (МУ-ын ЗГ, ГЯ, 2000) тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж байна.

Хүснэгт 3. Жендерийн талаархи мэдлэг, хандлага ба боловсролын түвшний хоорондох хамаарал, хүйсээр.

ЖЕНДЕРИЙН ТАЛААРХИ МЭДЛЭГ, ХАНДЛАГА	Бүрэн дундаас дээш боловсролтой залуучууд			
	Эрэгтэй Бүгдэд эзлэх хувь, %	Бүгд	Эмэгтэй Бүгдэд эзлэх хувь, %	Бүгд
<b>Жендерийн талаархи мэдлэг</b>				
Муу	30.4	46	33.3	33
Дунд	28.3	630	39.0	621
Сайн	36.8	19	54.1	37
	$\chi^2 =$	0.744	$\chi^2 =$	3.878
	df =	2	df =	2
	P =	0.689	P =	0.144
<b>Жендерийн хандлага</b>				
Үл зөвшөөрнө	28.4	676	39.5	684
Зөвшөөрнө	37.5	19	42.9	7
	$\chi^2 =$	0.630	$\chi^2 =$	0.330
	df =	1	df =	1
	P =	0.427	P =	0.855
<b>Бүгд</b>	28.6	695	39.5	691

Тэмдэглэгээ:  $\chi^2$  — ач холбогдлын түвшин: итгэмжлэх түвшин нь  $\alpha=95\%$   
 $P<0.0001$  бол хоёр хувьсагч хоорондоо маш хүчтэй хамааралтай.  
 $P<0.01$  бол дунд зэрэг хамааралтай .  
 $P<0.05$  бол сул хамааралтай.

Жендерийн талаар муу мэдлэгтэй гэсэн үнэлгээ авсан эрэгтэйчүүдийн 30.4%, эмэгтэйчүүдийн 33.3%, дунд зэрэг мэдлэгтэй эрэгтэйчүүдийн 28.3%, эмэгтэйчүүдийн 39%, жендерийн сайн мэдлэгтэй эрэгтэйчүүдийн 36.8%, эмэгтэйчүүдийн 54.1% нь бүрэн дундаас дээш боловсролтой байна. Жендерийн асуудалд хандах хандлагыг авч үзэхэд жендерийн асуудлыг зөвшөөрдөггүй эрэгтэйчүүдийн 28.4%, эмэгтэйчүүдийн 39.5%, зөвшөөрдөг эрэгтэйчүүдийн 37.5%, эмэгтэйчүүдийн 42.9% нь бүрэн дундаас дээш боловсролтой байна. Судалгаанд хамрагдсан залуучуудын боловсролын түвшин ба жендерийн талаархи мэдлэг, хандлага нь хоёр хүчин зүйлийн шинжилгээгээр хоорондоо статистикийн хамааралгүй гэсэн үр дүн гарав (Хүснэгт 3).

### Олон хүчин зүйлийн шинжилгээ

Сонгож авсан хүн ам зүйн болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлс, жендерийн талаархи мэдлэг хандлагыг боловсролын түвшинд хэрхэн нөлөөлж байгааг олон хүчин зүйлийн ложистик регрессийн шинжилгээгээр шалгаж үзье.

Энд, үл хамаарах бүх хувьсагчид нэрлэсэн түвшний хэмжигдэхүүн, харин хамаарах хувьсагч болох боловсролын түвшин нь (бүрэн дунд ба түүнээс доош боловсролтой, бүрэн дундаас дээш боловсролтой гэсэн 2-хон сонголттой) “dummy” хувьсагч юм.

Логарифмын харьцаа, ач холбогдлын коэффициентийг хүн ам зүйн хүчин зүйл, нийгэм, эдийн засгийн хүчин зүйл, жендерийн талаархи мэдлэг, хандлагын хэд хэдэн загвараар (Загвар А, Загвар В, Загвар С) эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд тус тусд нь Хүснэгт 4, 5-т харуулав. Бүх загварт таамаглалын үнэний шалгуур  $p < 0.001$  үед хүчин зүйлсийн хамаарал өндөр, харин  $p < 0.05$  үед хүчин зүйлсийн хамаарал дунд түвшинд байна гэж үзлээ. Сонгосон загваруудад үнэний хувийн харьцаа  $\chi^2$  утга буурсан бөгөөд бүгд маш хүчтэй ( $p < 0.0001$ ) хамааралтай байна.

Хүснэгт 4. Эрэгтэйчүүдийн хувьд боловсролын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийн ложистик регрессийн үр дүн, үл хамаарах хувьсагчдын сонгосон байдлаар

Үл хамаарах хувьсагчид	Логарифмын харьцаа (Odds ratio)		
	Загвар А	Загвар В	Загвар С
<b>ХҮН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛС</b>			
<b>Нас</b>			
17-21	1.00	1.00	1.00
22-25	1.26	0.80	0.78
26 ба түүнээс дээш	2.09	1.49	1.51
<b>Сууршил</b>			
Хөдөө	1.00	1.00	1.00
Хот	1.93**	2.03**	2.06**
<b>Гэрлэлтийн байдал</b>			
Огт гэрлээгүй	1.00	1.00	1.00
Гэрлэж байсан	.097	0.79	0.79
Хамт амьдардаг	1.48	1.41	1.40
<b>Мэргэжил эзэмшсэн эсэх</b>			
Мэргэжилтэй	1.00	1.00	1.00
Мэргэжилгүй	0.002***	0.003***	0.003***
<b>НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС</b>			
<b>Орлогын хараат байдал</b>			
Хараат		1.00	1.00
Хараат бус		3.76***	3.70***
<b>Амьдралд хамгийн чухал зүйл</b>			
Боловсролоос бусад зүйлс		1.00	1.00
Мэдлэг, боловсрол		0.56	0.52
<b>Боловсролоо дээшлүүлэх боломж</b>			
Боломжгүй		1.00	1.00
Боломжтой		0.67	0.72
<b>ЖЕНДЕРИЙН ТАЛААРХИ МЭДЛЭГ, ХАНДЛАГА</b>			
<b>Жендерийн талаархи мэдлэг</b>			
Муу			1.00
Дунд			0.43
Сайн			0.95
<b>Жендерийн хандлага</b>			

Үл зөвшөөрнө			1.00
Зөвшөөрнө			2.31
Constant	0.81	1.02	2.09
2LL $\chi^2$	389.20***	311.78***	308.77***

\*\*\*  $p < 0.0001$ ; \*\*  $p < 0.05$  түвшинд ач холбогдлын коэффициентийг тооцов.

Тайлбар: Загвар А: Хүн ам зүйн хүчин зүйл ба эрэгтэйчүүдийн боловсролын түвшин  
 Загвар В: Хүн ам зүйн хүчин зүйл, нийгэм, эдийн засгийн хүчин зүйл ба эрэгтэйчүүдийн боловсролын түвшин  
 Загвар С: Хүн ам зүйн хүчин зүйл, нийгэм, эдийн засгийн хүчин зүйл, жендерийн талаархи мэдлэг, хандлага ба эрэгтэйчүүдийн боловсролын түвшин

Эрэгтэйчүүдийн хувьд хүн ам зүйн хүчин зүйлсийг төлөөлүүлэн сонгож авсан хувьсагчдыг Загвар А-д үзүүлэв. Эрэгтэйчүүдийн сууршил ( $p=0.01$ ), мэргэжил эзэмшсэн байдал ( $p < 0.000$ ) нь тэдний боловсролын түвшинтэй статистикийн ач холбогдол бүхий хамааралтай, нас, гэрлэлтийн байдал нь статистикийн хамааралгүй байна.

Харин нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийг төлөөлүүлэн сонгож авсан хувьсагчдыг нэмэхэд (Загвар В) эрэгтэйчүүдийн сууршил ( $p=0.014$ ), мэргэжил эзэмшсэн байдал ( $p < 0.000$ ), орлогын хувьд бусдаас хараат эсэх ( $p < 0.000$ ) нь статистикийн ач холбогдол бүхий хамааралтай байв. Харин бусад хувьсагчид хамааралгүй байлаа.

Хамгийн сүүлийн Загвар С-д сонгосон бүх бүлэг хувьсагчдын хавсарсан нөлөөллийг авч үзэхэд эрэгтэйчүүдийн хувьд Загвар В-д хамааралтай байсан хувьсагчид бүгд ач холбогдол бүхий түвшинд статистикийн хамааралтай хэвээр, бусад хувьсагчид эрэгтэйчүүдийн боловсролын түвшинтэй статистик хамааралгүй гэж гарчээ.

Хүснэгт 5. Эмэгтэйчүүдийн хувьд боловсролын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийн ложистик регрессийн үр дүн, үл хамаарах хувьсагчдын сонгосон байдлаар

Үл хамаарах хувьсагчид	Логарифмын харьцаа (Odds ratio)		
	Загвар А1	Загвар В1	Загвар С1
<b>ХҮН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛС</b>			
<b>Нас</b>			
17-21	1.00	1.00	1.00
22-25	5.69***	5.39**	5.70**
26 ба түүнээс дээш	4.37**	3.70**	4.44**
<b>Сууршил</b>			
Хөдөө	1.00	1.00	1.00
Хот	0.95	0.74	0.67
<b>Гэрлэлтийн байдал</b>			
Огт гэрлээгүй	1.00	1.00	1.00
Гэрлэж байсан	0.58	0.73	0.63
Хамт амьдардаг	0.74	1.14	1.16
<b>Мэргэжил эзэмшсэн эсэх</b>			
Мэргэжилтэй	1.00	1.00	1.00
Мэргэжилгүй	0.002***	0.003***	0.003***
<b>НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС</b>			

<b>Орлогын хараат байдал</b>			
Хараат		1.00	1.00
Хараат бус		1.82	1.80
<b>Амьдралд хамгийн чухал зүйл</b>			
Боловсролоос бусад зүйлс		1.00	1.00
Мэдлэг, боловсрол		1.32	1.41
<b>Боловсролоо дээшлүүлэх боломж</b>			
Боломжгүй		1.00	1.00
Боломжтой		1.68	1.77
<b>ЖЕНДЕРИЙН ТАЛААРХИ МЭДЛЭГ, ХАНДЛАГА</b>			
<b>Жендерийн талаархи мэдлэг</b>			
Муу			1.00
Дунд			3.40**
Сайн			2.53
<b>Жендерийн хандлага</b>			
Үл зөвшөөрнө			1.00
Зөвшөөрнө			4.93
Constant	1.86	1.01	0.32
2LL $\chi^2$	330.94***	279.20***	274.94***

\*\*\*  $p < 0.0001$ ; \*\*  $p < 0.05$  түвшинд ач холбогдлын коэффициентийг тооцов.

Тайлбар: Загвар А1: Хүн ам зүйн хүчин зүйл ба эмэгтэйчүүдийн боловсролын түвшин  
 Загвар В1: Хүн ам зүйн хүчин зүйл, нийгэм-эдийн засгийн хүчин зүйл ба эмэгтэйчүүдийн боловсролын түвшин  
 Загвар С1: Хүн ам зүйн хүчин зүйл, нийгэм-эдийн засгийн хүчин зүйл, Жендерийн талаарх мэдлэг, хандлага ба эмэгтэйчүүдийн боловсролын түвшин

Загвар А1-д эмэгтэйчүүдийн хувьд хүн ам зүйн хүчин зүйлсийг төлөөлүүлж сонгож авсан хувьсагчуудыг харуулав. Эмэгтэйчүүдийн нас боловсролын түвшинтэй статистикийн дунд түвшний ач холбогдол бүхий хамааралтай ( $p < 0.000$ ,  $p = 0.003$ ), мэргэжил эзэмшсэн байдал ( $p < 0.000$ ) нь боловсролын түвшинтэй статистикийн өндөр хамааралтай гарсан байна.

Загвар В1-д нийгэм, эдийн засгийн хүчин зүйлээр сонгож авсан хувьсагчуудыг нэмж үзэхэд эмэгтэйчүүдийн нас ( $p = 0.002$ ,  $p = 0.019$ ), мэргэжил эзэмшсэн байдал ( $p < 0.000$ ) нь өмнөх загварын нэгэн адил статистикийн ач холбогдол бүхий түвшинд эмэгтэйчүүдийн боловсролын түвшинд нөлөөлтэй байна. Харин бусад хувьсагчид нь энэ загварт эмэгтэйчүүдийн боловсролын түвшинтэй статистикийн хамааралгүй байв.

Загвар С-д эмэгтэйчүүдийн хувьд хүн ам зүйн хүчин зүйлс, нийгэм эдийн засгийн хүчин зүйлс, жендерийн талаархи мэдлэг, хандлага зэрэг бүлэг хувьсагчуудын хавсарсан нөлөөллийг харуулсан бөгөөд ийнхүү шинжилж үзэхэд эмэгтэйчүүдийн нас ( $p = 0.002$ ,  $p = 0.009$ ), мэргэжил эзэмшсэн байдал ( $p < 0.000$ ) зэрэг нь өмнөх загваруудын нэгэн адил эмэгтэйчүүдийн боловсролын түвшинтэй статистикийн ач холбогдол бүхий түвшинд хамааралтай хэвээр, мөн жендерийн талаархи мэдлэг ( $p = 0.045$ ) нь ач холбогдлын дунд түвшинд хамааралтай байхад бусад хувьсагчид нь хамааралгүй байлаа.

Хүснэгт 6. Залуучуудын боловсролын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийн ложистик регрессийн үр дүн, үл хамаарах хувьсагчдын сонгосон байдлаар

Үл хамаарах хувьсагчид	Логарифмын харьцаа (Odds ratio)	
	Эрэгтэй	Эмэгтэй
<b>ХҮН АМ ЗҮЙН ХҮЧИН ЗҮЙЛС</b>		
<b>Нас</b>		
17-21	1.00	1.00
22-25	0.78	5.70**
26 ба түүнээс дээш	1.51	4.44**
<b>Сууршил</b>		
Хөдөө	1.00	1.00
Хот	2.06**	0.67
<b>Гэрлэлтийн байдал</b>		
Огт гэрлээгүй	1.00	1.00
Гэрлэж байсан	0.79	0.63
Хамт амьдардаг	1.40	1.16
<b>Мэргэжил эзэмшсэн эсэх</b>		
Мэргэжилтэй	1.00	1.00
Мэргэжилгүй	0.003***	0.003***
<b>НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИН ЗҮЙЛС</b>		
<b>Орлогын хараат байдал</b>		
Хараат	1.00	1.00
Хараат бус	3.70***	1.80
<b>Амьдралд хамгийн чухал зүйл</b>		
Боловсролоос бусад зүйлс	1.00	1.00
Мэдлэг, боловсрол	0.52	1.41
<b>Боловсролоо дээшлүүлэх боломж</b>		
Боломжгүй	1.00	1.00
Боломжтой	0.72	1.77
<b>ЖЕНДЕРИЙН ТАЛААРХИ МЭДЛЭГ, ХАНДЛАГА</b>		
<b>Жендерийн талаархи мэдлэг</b>		
Муу	1.00	1.00
Дунд	0.43	3.40**
Сайн	0.95	2.53
<b>Жендерийн хандлага</b>		
Үл зөвшөөрнө	1.00	1.00
Зөвшөөрнө	2.31	4.93
Constant	2.09	0.32
2LL $\chi^2$	308.766***	274.94***

\*\*\*  $p < 0.0001$ ; \*\*  $p < 0.05$  түвшинд ач холбогдлын коэффициентийг тооцов.

Хүснэгт 6-д шинжилгээний оновчтой загварыг хоёр хүйсээр зэрэгцүүлж харуулав. Ийнхүү харж үзэхэд хүснэгтэнд гарсан үр дүн нь монгол улсын залуучуудын боловсролын түвшинд нөлөөлж буй хүчин зүйлс эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд нэлээд ялгаатай байгааг харуулж байна.

Судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдийн хувьд оршин сууж буй газрын байршил нь тэдний дээд боловсрол эзэмшихэд статистикийн дунд түвшинд ач холбогдол бүхий хамааралтай байна. Хотод амьдардаг эрэгтэйчүүдийн

бүрэн дундаас дээш боловсрол эзэмших магадлал нь хөдөө амьдардаг эрэгтэйчүүдийнхээс 2 дахин өндөр ( $p=0.013$ ) байна. Харин эмэгтэйчүүдийн хувьд оршин сууж буй газрын байршил боловсролын түвшинтэй статистикийн хамааралгүй гарчээ.

Монголын хүн ам зүйн 1994 оны судалгаагаар боловсролын түвшин дэх хүйсийн ялгаа хот, хөдөөгийн хувьд нэлээд зөрүүтэй гарсан байна. Шилжилтийн үеийн эхний жилүүдэд хот, хөдөөгийн охид хөвгүүдийн сургуульд хамрагдалтын түвшин эрс ялгаатай болж ирсэн бөгөөд ялангуяа малчин айлын хөвгүүдийн сургуульд хамрагдалт нэлээд буурсан юм (А.Солонго, Б.Робинзон, 1999). Энэ нь өнөөгийн залуучуудын боловсролын түвшин дэх хүйсийн ялгаатай байдалд хот хөдөөгийн байршил нөлөөлсөн байж болох талтай.

Судалгаанд хамрагдсан 22-25 настай эмэгтэйчүүдийн бүрэн дундаас дээш боловсрол эзэмших магадлал нь 17-21 настай эмэгтэйчүүдийнхээс бараг 6 дахин ( $p=0.002$ ), мөн 26, түүнээс дээш настай эмэгтэйчүүдийн хувьд энэ нь 17-21 настай эмэгтэйчүүдийнхээс 4 дахин өндөр байна ( $p=0.009$ ). Харин эрэгтэйчүүдийн хувьд статистикийн ач холбогдлын хамаарал байхгүй байна.

2000 оны Хүн ам, орон сууцны тооллогын үр дүнгээс харахад 7-29 насны хүн амын сургуульд хамрагдалтын байдал хүйсийн хувьд нэлээд ялгаатай байв (ҮСГ, 2002). Бүх насанд эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс сургуульд хамрагдан суралцах нь илүү байна. Хүйсийн энэ ялгаа боловсролын дээд түвшинд (энд мэргэжлийн сургууль, тусгай дунд, коллеж, их, дээд сургуулийн боловсрол хамрагдана) бүр илүү байгаа юм. Албан ёсны мэдээнээс харахад 35 хүртэлх насны боловсролтой эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү олон байна (ҮСГ, 2002). Эндээс бүрэн дундаас дээш боловсролын түвшин дэх хүйсийн ялгаатай байдалд залуучуудын нас (боловсролын тогтолцоонд бүрэн дундаас дээш боловсрол эзэмших нас нь 19-27) тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлдэг нь ажиглагдаж байна.

Залуучуудын мэргэжил эзэмшсэн байдал нь боловсролын түвшинтэй статистикийн өндөр ач холбогдол бүхий хамааралтай байна. Мэргэжилгүй эрэгтэйчүүдийн бүрэн дундаас дээш боловсролтой байх магадлал нь мэргэжилтэй эрэгтэйчүүдийнхээс бага ( $p<0.000$ ) байна. Эмэгтэйчүүдийн хувьд энэ нь мөн адил бага байв ( $p<0.000$ ).

Эрэгтэйчүүдийн хувьд орлогын хараат байдлыг авч үзэхэд өөрийн гэсэн орлогын ямар нэгэн эх үүсвэртэй буюу орлогын хувьд бусдаас хараат бус эрэгтэйчүүдийн бүрэн дундаас дээш боловсрол эзэмших магадлал нь орлогын хувьд бусдаас хараат байдалд байдаг эрэгтэйчүүдийнхээс бараг 4 дахин өндөр байна ( $p<0.000$ ). Харин эмэгтэйчүүдийн хувьд орлогын хараат байдал нь боловсролын түвшинтэй нь статистикийн хамааралгүй байна.

Эдийн засгийн шилжилт боловсролын салбарт хүнд цохилт өгч нэг хүн амд ногдох боловсролын зардал 1991-1996 онд 53 хувиар буурсан байна. 1995 оноос төлбөртэй сургалт зөвшөөрөгдсөнөөс хойш эцэг эхийн төлбөрийн чадвар болон хүүхдүүдийнхээ боловсролд анхаарах байдлаас охид хөвгүүдийн боловсрол эзэмших эсэх нь хамаарах болсон байна (А.Солонго, Б.Робинзон, 1999). Эцэг эхчүүдийн боловсрол дахь хөрөнгө оруулалт нь

охид хөвгүүдэд ялгаатай тусч байгаа бөгөөд тэд боловсролыг охидын ирээдүйн эдийн засгийн баталгаа, амьдрах боломж, харин хөвгүүдийн хувьд МАА, бизнесийн салбарт хүчээ үзэх боломжтой гэж үздэг болжээ (НҮБ, ЭХС, 2000). Эдгээр нөхцөл байдлаас шалтгаалж орлогын хувьд бусдаас хараат байдаг эрэгтэйчүүдийн боловсролын түвшин эмэгтэйчүүдийнхээс бага болсон байж болох юм.

Судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн хувьд жендерийн талаар дунд зэргийн мэдлэгтэй эмэгтэйчүүдийн бүрэн дундаас дээш боловсролтой байх магадлал нь жендерийн талаар муу мэдлэгтэй эмэгтэйчүүдийнхээс 3 дахин өндөр байна ( $p=0.045$ ). Энэ үзүүлэлт нь эрэгтэйчүүдийн хувьд боловсролын түвшинд нөлөөлөх хүчин зүйл болоогүй байна.

### Дүгнэлт

Судалгааны ажлын хүрээнд олон хүчин зүйлийн ложистик регрессийн шинжилгээр 17-35 насны залуучуудын боловсролын түвшинд залуучуудын нас, сууршил, мэргэжил эзэмшсэн эсэх, орлогын хараат байдал, жендерийн талаархи мэдлэг зэрэг олон хүчин зүйлс нөлөөлж байна гэдгийг шинжилж тодорхойлов. Мөн хоёр хүчин зүйлийн хамаарлыг  $\chi^2$  - ээр судалж үзээд залуучуудын боловсролын түвшинтэй нас, сууршил, гэрлэлтийн байдал, мэргэжилтэй эсэх, орлогын хараат байдал, амьдралд хамгийн чухал зүйл, зэрэг хувьсагчид статистикийн хамааралтайг тогтоолоо.

Судалгаагаар эцэг эхчүүд боловсрол дахь хөрөнгө оруулалтыг охидууддаа илүү хийх сонирхолтой байгаа нь ажиглагдаж байна. Учир нь орлогын хараат байдал бусад хүчин зүйлстэй хавсарсан нөлөөллөөр эрэгтэйчүүдийн хувьд боловсролын түвшинтэй статистикийн өндөр ач холбогдол бүхий түвшинд хамааралтай ( $p<0.000$ ), харин эмэгтэйчүүдийн хувьд статистикийн хамааралгүй байна. Энэ нь эмэгтэйчүүд орлогын хувьд бусдаас хараат байсан ч энэ нь тэдний боловсролын түвшинд сөргөөр нөлөөлөхгүй гэсэн үг юм.

Залуучуудын оршин сууж буй газрын байршлаас шалтгаалаад дээд боловсрол эзэмших боломж ялгаатай байгаа нь судалгаагаар батлагдсан. Ихэнхи их, дээд сургууль коллеж нь хотод төвлөрсөн бөгөөд хөдөө орон нутагт дээд боловсрол олгох түвшний сургууль бараг байдаггүй, хөдөөнөөс хотод ирж суралцахад санхүүгийн маш их хүндрэл тулгардгаас хот, хөдөөгийн залуучуудын боловсролын түвшин нэлээд их ялгаатай байдаг байна. Тиймд хөдөөгийн залуучуудын боловсролд төр засгийн зүгээс илүү анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

Залуучуудын нас нь хоёр хүчин зүйлийн шинжилгээгээр судалж үзэхэд боловсролын түвшинтэй маш хүчтэй хамааралтай байсан бол олон хүчин зүйлсийн хавсарсан нөлөөллөөр зөвхөн эмэгтэйчүүдийн хувьд статистикийн дунд түвшний хамааралтай гарсан байна ( $p=0.002$ ,  $p=0.009$ ). Залуучуудын жендерийн талаархи мэдлэг, хандлага боловсролын түвшинд нөлөөлөхгүй гэж таамаглаж байсан боловч олон хүчин зүйлийн ложистик регрессийн шинжилгээгээр эмэгтэйчүүдийн хувьд жендерийн талаархи мэдлэгийн түвшин нь боловсролын түвшинтэй статистикийн дунд түвшний ач холбогдол бүхий хамааралтай гарсан байна ( $p=0.045$ ).

Судалгаа хийхээс өмнө залуучуудын амьдралдаа хамгаас чухалчилж үздэг зүйл нь (Бусад зүйлс, боловсрол гэсэн сонголттой) боловсролын түвшинд нөлөөлнө гэж таамаглаж байсан боловч олон хүчин зүйлийн шинжилгээний үр дүнд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд боловсролын түвшинтэй статистикийн хамааралгүй гарсан байна. Харин хоёр хүчин зүйлийн шинжилгээгээр зөвхөн эрэгтэйчүүдийн хувьд статистикийн дунд зэргийн хамааралтай байв ( $p=0.001$ ).

Гэхдээ нэг сонирхолтой үр дүн ажиглагдсан нь боловсролыг амьдралдаа хамгийн чухал зүйл хэмээн үзсэн бүрэн дундаас дээш боловсролтой эмэгтэйчүүдийн эзлэх хувь эрэгтэйчүүдийнхээс бараг 20 орчим пунктээр өндөр байлаа. Тиймд цаашид эрэгтэйчүүдийн боловсролын түвшинг дээшлүүлэхийн тулд юуны өмнө эцэг, эх, сурган хүмүүжүүлэгч нар хөвгүүдийн боловсролд илүү анхаарлаа хандуулж мэдлэг, боловсролын чухлыг ойлгуулж өгөх шаардлагатай байна.

### **Зөвлөмж, цаашид шаардлагатай судалгааны ажлын чиглэл:**

Судалгааны үр дүнг үндэслэн дараахь зөвлөмж, саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

- ◆ Хөдөө орон нутагт их, дээд сургуулиудын салбаруудыг байршуулж ингэснээр хөдөөгийн залуучуудын дээд боловсрол олж авах боломжийг нэмэгдүүлэх.
- ◆ Эцэг, эхчүүд охидынхоо боловсролд илүү ач холбогдол өгч, дээд боловсрол эзэмшихэд нь хөвгүүдээсээ илүү хөрөнгө оруулалт хийдэг хандлагыг өөрчлөх шаардлагатай.
- ◆ Дээд боловсрол олгох түвшний сургалтанд хүйсийн тэнцвэрт байдлыг хангахын тулд ЕБС-ын 9-р ангид элсэн суралцах сурагчдын хувьд босго тавихдаа хүйсийн байдлыг анхаарах.

Цаашид шаардлагатай судалгаа, шинжилгээний ажлын чиглэл:

- ◆ Хөдөө орон нутагт шинээр их, дээд сургууль байгуулах талаар нарийн судалгаа шинжилгээ хийх.
- ◆ Хэдийгээр эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийг бодвол боловсролын түвшин өндөр байгаа боловч боловсролоос хүртэх ашиг тусыг эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хувьд гүнзгийрүүлж судлах.
- ◆ Эцэг, эхчүүд охид, хөвгүүдээ сургах талаархи шийдвэрээ хэрхэн гаргадаг, мөн боловсрол дахь хөрөнгө оруулалтыг хэрхэн хийдэг талаар чанарын гүнзгийрүүлсэн судалгаа хийх.



## Ном зүй

---

1. МУ-ын Засгийн Газар, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, “Монголын хүний хөгжлийн илтгэл”, 1997
2. МУ-ын Засгийн Газар, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, “Монголын хүний хөгжлийн илтгэл”, 2000. /48-49 дүгээр тал/
3. МУ-ын Үндэсний Статистикийн Газар, “Монгол улс дахь хүйсийн ялгаатай байдал” Сэдэвчилсэн судалгаа, 2002. / 3 дугаар бүлэг/
4. А.Батжаргал, “Боловсрол ба жендер”, 2001
5. Шинжлэх Ухаан Боловсролын Яам, Статистикийн Мэдээлэл, 1996
6. Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам, Статистикийн Мэдээлэл, 2001
7. Д.Гэрэлцэцэг, Шилжилтийн үеийн залуучуудын боловсрол, 1998
8. МУ-ын Үндэсний Статистикийн Газар, 2000 оны Хүн ам, орон сууцны тооллого: Үндсэн үр дүн, 2001
9. ХАЗССТ, “Монголын залуучуудын жендерийн байдал судалгаа”, 1999
10. ХАЗССТ, Монголын хүн ам зүйн судалгаа: Үндсэн илтгэл, 1994. /22-25 дугаар тал/
11. МУ, ҮСГ, Хүүхэд, хөгжил-2000 судалгаа, Монгол улс Үндэсний тайлан. /21-26 дугаар тал/
12. МУ-ын Засгийн Газар, Гэгээрлийн Яам, Монголын боловсролын салбарыг 2000-2005 онд хөгжүүлэх стратеги, Улаанбаатар 2000. /15-16 дугаар тал/
13. ЭМСТ, “Хүйсийн мэдээлэл” No 2, 1997. /Гуравдугаар бүлэг/
14. НҮБ-ын ЭХС, Монголын эмэгтэйчүүд: Шилжилтийн үеийн дэвшлийг зураглахуй. 2000 он. /”Эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь” сэдэв/
15. Нийгмийн Хөгжлийн Төв Зөвлөх Нэгж, “Нийгмийн Хөгжил сэдэвт сургалтын хөтөлбөр”, 1997 /4-8 дугаар тал/
16. Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Үндсэн Хууль, 1992. /2 дугаар бүлэг/
17. А.Солонго, Б.Робинзон, 1999. Редактор: Б.Вальтерс, П.Лувсандорж гэх мэт бусад. Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургууль, Манчестерийн Их Сургууль, “Монголын эдийн засаг”, шилжилтийн эдийн засгийн гарын авлага, 1999 / 346-350 дугаар тал/